

**НЦҮТ/ТХБ¹-НЫ ДУНД ТӨСӨЛ ШАЛГАРУУЛАХ ЗАРЫН ДАГУУ ИРСЭН
ТОДРУУЛГЫН ХАРИУ**

№ 1

2021 оны 5-р сарын 4

№	Төсөл ирүүлэгчийн асуулт	НҮБ-ын Хүн амын сангийн хариулт
1	Төслийн зөвшөөрөгдөх, үл зөвшөөрөгдөх ямар зардлууд байх вэ?	<p><u>Зөвшөөрөгдөх зардлууд:</u></p> <ol style="list-style-type: none"> 1. НЦҮТ/ТХБ-д байрлаж байгаа үйлчлүүлэгчдийн эдийн засгийн боломж болон амьдрах ухааны ур чадвар, өөртөө итгэх итгэлийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, үйлчилгээг өргөжүүлэхэд чиглэсэн зардлууд. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах зардал - Шаардлагатай сургалт зохион байгуулах зардал 2. НЦҮТ/ТХБ-ны үйлчилгээг өргөжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд байрны нөхцлийг ээлтэй болгоход чиглэсэн зардлууд <ul style="list-style-type: none"> - Шаардлагатай барилгын засварын ажил - Шаардлагаатй тоног төхөөрөмж <p><u>Үл зөвшөөрөгдөх зардлууд:</u></p> <p>Дараахь зардлуудыг дэмжихгүй. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Барилга байшин шинээр барих зардал 2. НЦҮТ/ТХБ-ны ажилчдын цалин, урамшуулал 3. Шатахууны болон албан томилолтын зардал 4. Үзэсгэлэн худалдаа зохион байгуулах зардал 5. Олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах зардал 6. НЦҮТ/ТХБ-ны бодит хэрэгцээнээс хэтэрсэн, аль эсвэл түүний үйл ажиллагааг өргөжүүлэх, хөгжүүлэхэд ач холбогдолгүй зардлууд 7. Өртгийг нь зах зээлийн бодит байдлаас хэт өндрөөр тооцсон бүх зардлууд 8. Зайлшгүй шаардлагатайгаас бусад тоног төхөөрөмж, эд хогшил, бараа материал, үйлчилгээний зардлууд
2	Энэхүү төслийн нийт зардал хэд байх вэ, мөн 2 зорилт болох үйл ажиллагаа, үйлчилгээгээ өргөжүүлэх, байрны нөхцлийг сайжруулах чиглэлд төсвийн төсөв хэд байх вэ?	<p>Төслийн нийт зардалд ямар нэгэн дээд болон доод хязгаарлалт тавихгүй боловч нэг төслийн дундаж зардлыг төслийн нийт үргэлжлэх хугацаанд (2021-2023 он) дунджаар 80-100 сая төгрөг байхаар төсөөлж байна. Төслүүд нь заавал тухайн дүнг удирдлага болгох шаардлагагүй.</p> <p>Учир нь төслийн санал бүр тухайн НЦҮТ/ТХБ-ны бодит эрэлт хэрэгцээ, онцлог, нөөц, боломжид үндэслэсэн, эдийн засаг, ниймгийн хувьд ач холбогдол өндөртэй байх нь чухал юм.</p>

¹ НЦҮТ/ТХБ – Нэг Цэгийн Үйлчилгээний Төв/Түр Хамгаалах Байр

		Төсвийн хуваарилалтад ямар нэгэн хязгаарлалт тавихгүй бөгөөд НЦҮТ/ТХБ-ууд нь төслийн онцлогт тохируулж төсвийн хуваарилалтыг хийж ирүүлнэ.
3	Орон нутгийн Засаг дарга, ИТХ-аас ямар ямар дэмжлэг үзүүлсэн байх вэ, Жишээ нь эдийн засгийн хувьд юмуу, хүний нөөц юм уу гэх мэт дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү?	<p>Үүнд орон нутгийн зүгээс үзүүлсэн бүхий л хэлбэрийн дэмжлэгийг багтааж үзнэ. Тухайлбал:</p> <ol style="list-style-type: none"> 1. Эдийн засгийн буюу санхүүгийн дэмжлэг 2. Хүний нөөцийн буюу ажиллах хүчний цалин хангамж 3. Ухуулга нөлөөллийн 4. Бүтэц зохион байгуулалт 5. Уялдааг хангах зохицуулалтын 6. Мэргэжил арга зүйн удирдлагаар хангах зэрэг байж болно.